

ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГА: ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

А.Бямбажаргал, Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор

Б.Гончигсумлаа, МУИС-ийн ХЗС-ийн магистр

Д.Ренчиндорж, МУИС-ийн ХЗС-ийн магистрант

2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцуулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” гэх нэмэлт орсон билээ. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн түвшинд шүүгчийн хариуцлагыг бие даан эрхлэх институцийг шинээр бий болгосон нь цаашид энэхүү харилцааг зохицуулах эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай болоод байна.

2017 онд Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд шүүхийн хариуцлагын тогтолцоо, түүний

дотор сахилгын хэрэг маргаан шийдвэрлэж буй ажиллагаанд дүн шинжилгээ хийж үр дүнг хэвлэн гаргасан юм. Хэдийгээр уг судалгааны ажил Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө хийгдсэн боловч агуулгын хувьд эдүгээ хөндөгдөж буй асуудлуудыг бүрэн хамарсан болно. Иймд дээрх судалгааны үндсэн дүгнэлт, бодлогын зөвлөмжийг хураангуйлан ННФ “Бодлогын асуудал”-ын шинэ дугаараараа бодлого боловсруулагч Та бүхэнд хүргэж байна. Хуулийн ажлын хэсгийн гишүүд болон бодлого боловсруулагчид өргөнөөр ашиглана гэдэгт найдаж байна.

“Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн хариуцлага” (судалгааны товчлол)-ыг дэлгэрэнгүйгээр нь “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2018 оны цуврал 1 (66)- ээс үзнэ үү.

Алтангэрэлийн БЯМБАЖАРГАЛ



МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйч мэргэжлээр суралцан төгссөн бөгөөд хожим БНСУ-ын Күүкмин их сургуулийн ХЗС-д Хууль зүйн докторын (Ph.D)

зэрэг хамгаалсан. Тэрээр эдүгээ МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхэлж байна.

Дугаржавын РЕНЧИНДОРЖ



МУИС-ийн ХЗС-ийн магистрант бөгөөд Үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг. ХНХЯ-ны хуулийн асуудал

хариуцсан ахлах шинжээчээр ажиллаж байна.

Базаррагчаагийн ГОНЧИГСУМЛАА



МУИС-ийн ХЗС-ийн магистр. Иргэний эрх зүй болон хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах, хэрэгжилтийг үнэлэх

чиглэлээр судалгаа хийдэг. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ажилтан.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дүгээр зүйлд “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” хэмээх зарчмыг тунхагласан. Энэхүү зарчмын хэрэгжих гол баталгаа нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын хэмжүүр. Шүүхийн бие даасан байдал хангагдаагүй нөхцөлд шүүгчийн хараат бус байдал алдагдах бөгөөд үүнээс үүдэн иргэдийн үндсэн хуулиар баталгаажсан шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх нь гарцаагүй юм. Манай улсын хувьд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх гол институтц нь Үндсэн хууль болон бусад хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) билээ.

Харин шүүгчийн хараат бус байдлын нөгөө талд нь шүүгчийн хариуцлага буюу шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлж, шүүн таслах ажиллагааг эрхлэх явцдаа шүүгчийн ёс зүйн зөрчил гаргах болон хууль зөрчдөг, хариуцлага хүлээдэггүй дархан эрхтэй этгээд болгохгүй байх тэнцвэржүүлэгч механизм оршдог. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмуудын оршил хэсэгт шүүхийн тогтолцоо болон шүүгчийн ёс зүй, үнэнч шударга байдалд итгэх олон нийтийн итгэл нь өнөөгийн ардчилсан нийгмийн амин сүнс болохыг тунхагласан. Тус зарчмын 13 дахь хэсэгт шүүхийн бие даасан болон шүүгчийн ёс зүйтэй байдлыг шүүхийн тогтолцооны үр ашигтай, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл хэмээн тайлбарласан. Өөрөөр хэлбэл, шүүгчийн хариуцлагын асуудал нь энэ тогтолцооны амин чухал хэсэг болохыг тод томруунаар харуулж байгаа юм. Тийм ч учраас шударга ёсыг тогтоох шүүхийн тогтолцоо нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх замаар биеллээ олдог.

Монгол Улсын шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо буюу шүүгчийн ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд цөөнгүй асуудал тулгамдсан шинжтэй байна. Тухайлбал, (1) *шүүхийн ёс зүйн хорооны маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд*: Нотлох баримт бүрдүүлэх, ёс зүйн хорооны ажлын албаны эрх хэмжээ, ёс зүйн хорооны гишүүний хараат

бус байдал, (2) *шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцооны хүрээнд*: сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны зохист харьцаа ба ёс зүйн гомдлыг шийдвэрлэх үе шат, (3) *шүүгчийн хариуцлага, түүнтэй холбогдох эрх зүйн орчны хүрээнд*: ёс зүйн хорооны эрх зүйн байдал болон дүрмийн давхардал ба эрэмбэ зэрэг тулгамдсан шинжтэй асуудлууд байна.

1. Шүүгчийн сахилгын маргааныг шийдвэрлэх тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд

Шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо хянан шийдвэрлэдэг байхаар 2012 оны Шүүхийн тухай багц хуульд заасан бөгөөд Шүүхийн ёс зүйн хороог хуульч, эрдэмтэн судлаач зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсын Ерөнхийлөгч батлах ба өмгөөлөгч, шүүгч, прокурор оролцохыг хориглосон. Одоогийн тогтолцоогоор шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах 4 үе шат дамжин хэрэгжиж байна. Үүнд:

1. *Гомдол хүлээн авах, шалгах*: Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдлыг Шүүхийн Ёс Зүйн Хороо (ШЕЗХ)-ны ажлын алба хүлээн авч, хорооны даргад танилцуулан, дарга нь хянан шалгах гишүүнд хуваарилна.¹ Гомдол шалгах гишүүн асуудлыг гомдолд холбогдох шүүгчид танилцуулж, хариу тайлбар, шаардлагатай баримт, мэдээлэл цуглуулна. Баримт мэдээлэл цуглуулахдаа гишүүн нь захирамжаар ажлын албанд даалгавар өгч болно. Гомдлыг шалгаж дууссаны дараа танилцуулга бичиж хорооны даргад танилцуулах бөгөөд дарга, хуралдаан зарлаж, гомдлыг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнийг томилно. Уг бүрэлдэхүүнд гомдол шалгасан гишүүн заавал орох ёстой. 2002-2013 оны тогтолцоонд Шүүхийн

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан “Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм”-ийн 3.2

сахилгын хорооны ажлын алба гомдол хүлээн авч, сахилгын хорооны дарга, хорооны аль гишүүнээр гомдлыг шалгуулах асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээтэй² байсан бол одоогийн тогтолцоогоор гишүүдийн нэрийн дарааллаар гомдол шалгах гишүүнийг томилох зохицуулалттай болсон.

2. *Гомдол хянан хэлэлцэх, сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх:* ШЕЗХ нь гомдлыг хянан үзэж сахилгын хэрэг үүсгэх, эс үүсгэх асуудлыг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ. ШЕЗХ-ны даргын томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаан хуралдуулж ШЕЗХ-ны тогтоолоор сахилгын хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэж³ байна. 2002 он хүртэл шүүгчид сахилгын хэрэг үүсгэх асуудлыг тухайн шатны ерөнхий шүүгч шийдвэрлэж, шүүгчийн хараат бус байдалд ч нөлөөлөх магадлалтай байсан бол 2002-2013 онд шүүгчид сахилгын хэрэг үүсгэх эсэх асуудлыг зөвхөн Шүүхийн сахилгын хорооны дарга шийдвэрлэх эрх хэмжээтэй байсан юм. Харин 2013 оноос хойш ШЕЗХ нь зайлшгүй 3 гишүүний олонхын саналаар сахилгын хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг болсноор нэг субъектийн саналаар шүүгчид сахилгын хэрэг үүсгэдэг тогтолцоо өөрчлөгдсөн.
3. *Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх:* ШЕЗХ-ны 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаас сахилгын хэрэг үүсгэх тогтоол гарсан бол сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүх гишүүдийн бүрэлдэхүүнтэй хуралдаан хийж, уг хэргийг хянан шийдвэрлэнэ.⁴ Уг хуралдаанаар шүүгчид сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсаныг гомдол гаргагч эс зөвшөөрвөл, бүх гишүүдийн хуралдаанд давж заалдах эрхтэй. Бүх гишүүдийн хуралдааны магадлалаар сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох,

гомдлыг дахин шалгуулах, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгож, дахин шалгах эсвэл хэвээр үлдээх шийдвэрүүдийн алт нэгийг гаргана. ШЕЗХ-ны хувьд бүх гишүүдийн магадлал нь шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагааг шийдвэрлэж буй эцсийн шийдвэр бөгөөд харин түүнд шүүхийн журмаар давах, цаашид хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байна.

2002-2013 оны тогтолцоонд Шүүхийн сахилгын хороо (ШСХ) 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг байсан бөгөөд уг шийдвэрт давж заалдах журмаар ШСХ-ны бүх гишүүдийн хуралдаанд гомдол гаргах эрхтэй байсан. Шүүхийн сахилгын хорооны бүх гишүүдийн хуралдаанаас гарсан шийдвэр нь тухайн сахилгын хэргийн хувьд эцсийн шийдвэр бөгөөд түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй байсан. Өөрөөр хэлбэл, Шүүхийн сахилгын хороо нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг бие даан эцэслэн шийдвэрлэдэг байжээ.

4. *Давж заалдах, хяналтын журмаар шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх:* Одоогийн тогтолцоогоор ШЕЗХ-ны бүх гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг шийдвэрлэдэг. Гэвч энэ нь шүүгчийн ёс зүйн гомдлыг шийдвэрлэх эцсийн үе шат биш бөгөөд магадлалыг эс зөвшөөрвөл уг магадлалын талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Мөн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Улсын дээд шүүх рүү хяналтын журмаар гомдол гаргаж болдог тул шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг шүүхийн байгууллага эцэслэн шийдвэрлэж байна. Энэ нь нэг талаас шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу процессын шударга ёсыг шүүхээс хамгаалж буй баталгааны илрэл юм.

² Монгол Улсын 2002 оны Шүүхийн тухай хууль

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан "Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм"-ийн 4.6

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 167 дугаар зарлигаар баталсан "Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм"-ийн 5.1

1993-аас 2020 он хүртэл хэрэгжсэн Шүүгчийн ёс зүй, сахилгын хариуцлагын тогтолцоог доор хүснэгтэд харьцуулан харуулав.

№	Үе шат	Шүүгчийн сахилгын хороо (1993–2002)	Шүүхийн сахилгын хороо (2002–2013 он хүртэл)	Шүүхийн ёс зүйн хороо (2013 оноос хойш)	Шүүхийн тухай хуулийн төсөлд тусгасан Сахилгын хороо(2020 он)
1.	Хэргийн харьяалал	Шүүгчийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэхээр заасан боловч 1997 он хүртэл Шүүгчийн ёс зүйн дүрэмгүй байжээ.	Шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой, шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тухай гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэнэ.	Шүүгчийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> - Шүүхийн тухай хуульд заасан Шүүгчид хориглох зүйлс - Шүүгчийн ёс зүйн дүрэм - Хөдөлмөрийн харилцааны журам
2.	Гомдол, хүсэлт гаргах эрх бүхий субъект	Иргэд гомдол гаргана. Ерөнхий шүүгч нар сахилгын хэрэг үүсгэх эрхтэй.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бүх шатны ерөнхий шүүгч	Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд	Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд
3.	Гомдол, хүсэлтийг хүлээн авах	Сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий субъект	Ажлын алба	Ажлын алба	Ажлын алба
4.	Гомдлыг хуваарилах	-	Сахилгын хорооны дарга аль нэг гишүүнд хуваарилна.	Ёс зүйн хорооны дарга, гишүүдийн нэрсийн дарааллаар хуваарилна.	Сахилгын хорооны дарга, гишүүдийн нэрсийн дарааллаар хуваарилна.
5.	Гомдол шалгах ажиллагаа	Гомдол шалгах процесс тодорхойгүй.	Сахилгын хорооны дарга, гишүүн ажлын албанд даалгавар өгөх эрхтэй, хэдэн хэдэн гишүүн, ажилтан хамтран шалгаж болно.	Гишүүн шаардлагатай тохиолдолд баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч захирамж гаргана.	Гишүүн шаардлагатай тохиолдолд баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч захирамж гаргана.
6.	Гомдлыг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнийг томилох	-	-	Шалгах ажиллагаа дууссаны дараа Ёс зүйн хорооны дарга бүрэлдэхүүнийг томилж, тов зарлана.	Сахилгын хорооны дарга томилно.
7.	Шүүгчид сахилгын хэрэг үүсгэх	Ерөнхий шүүгч, УДШүүгч сахилгын зөрчил гаргасан эсэхээс ялгамжтайгаар тухайн шатны ерөнхий шүүгч нар сахилгын хэрэг үүсгэнэ.	Сахилгын хорооны дарга сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах нэмэлт шалгалт хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.	Гомдлыг хянан хэлэлцэх томилогдсон гишүүдийн хуралдаанаар сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэр гаргана.	Гишүүн гомдол мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шалгаж сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах шийдвэр гаргана.
8.	Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх	УДШ-ийн дэргэдэх ШСХ, Эсхүл тухайн шатны шүүхийн дэргэдэх ШСХ шийдвэрлэнэ.	Сахилгын хорооны 3 гишүүний бүрэлдэхүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэнэ.	Нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын хэргийг хянан шийдвэрлэнэ.	
9.	Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргах	Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч л УДШ-д гомдол гаргах боломжтой байсан.	Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанаар шийдвэрлэнэ.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэнэ.	
10.	Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналтын журмаар гомдол гаргах	Зөвхөн Улсын дээд шүүхэд сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч гомдол гаргах боломжтой. Иргэн гомдол гаргах боломжгүй байсан.	Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдааны магадлал эцсийн шийдвэр байна.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах боломжтой.	

2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа ба эрх зүйн ерөнхий зохицуулалт

ШЕЗХ-ны дүрмийн 2.9 дэх хэсэгт “... Ёс зүйн зүйн хорооны дарга, гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж, гомдлыг хянан хэлэлцэх хуралдаанаас тогтоол, бүх гишүүдийн хуралдаанаас магадлал гаргана” хэмээн заасан. Түүнчлэн уг дүрмийн 5.13-т “Ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны магадлалыг шүүгч, гомдол гаргагч эс зөвшөөрвөл магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж зохицуулсан. Энэ байдлаас үзвэл бүх гишүүдийн хуралдааны магадлалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тал гомдол гаргах эрхтэй болно. Гэтэл ШЕЗД-ийн 5.7.1- 5.7.5 дахь хэсэгт зааснаар магадлал нь таван төрөлтэй байх боломжтой. Өөрөөр хэлбэл, “Сахилгын шийтгэл ногдуулах, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, Сахилгын хэргийг дахин шалгуулах, Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хэвээр батлах, Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгож, гомдлыг дахин шалгуулахаар буцаах” гэх онцлогтой байна. Тэгвэл эдгээр магадлалаас маргааныг эцэслэн шийдвэрлээгүй буюу ямар нэг эрх зүйн үр дагавар бодитоор бий болоогүй байхад түүнд гомдол гаргах боломжтой гэсэн үг юм. Үүнээс үүдэн шүүгчид холбогдох ёс зүйн маргааныг эцэслэж шийдвэрлэгдээгүй байтал түүнд нь гомдол гаргах боломжтой болдог. Энэ байдал ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, шүүхийн ачааллыг ашиггүй нэмэгдүүлэх зэрэг сөрөг талтай.

3. Нотлох баримт бүрдүүлэх ажиллагааны тодорхойгүй байдал

Нотлох баримт бүрдүүлэх эрх хэмжээ тодорхойгүй

ШЕЗХ-ны дүрэм болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу ШЕЗХ нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэгтэй боловч нотлох баримт

бүрдүүлэх, шаардах эрх хэмжээ олгогдоогүйгээс ёс зүйн маргааныг бүрэн гүйцэд шалган шийдвэрлэхэд хүндрэл үүсэж байна.

Нотлох баримт бүрдүүлэх явц дахь ёс зүйн хорооны ажлын албаны эрх хэмжээ тодорхойгүй

ШЕЗХД-ийн 3.3.3-т “гишүүн шаардлагатай гэж үзвэл Ажлын албаны ажилтнаар баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч болно. Энэ тохиолдолд гишүүн захирамж гаргана. Захирамжид ажилтны хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон байна” гэж заасан байдаг. Нотлох баримтыг шинжлэн судлах асуудлын хүрээнд ШЕЗХ-ны дүрэмдажлын албаны ажилтнаар баримт мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч болохоор заажээ. Гэтэл нотлох баримт бүрдүүлэх ажиллагааны явцад ёс зүйн хорооны ажлын албаны ажилтны хувьд даалгаварт нь тусгагдаагүй боловч хэргийг хянан шийдвэрлэхэд чухал шаардлагатай нотлох баримт авах эсэх асуудал үүсэн гарч байна. Харин энэ тохиолдолд ажлын албаны ажилтан тийм нотлох баримтыг бүрдүүлэх буюу даалгаварт тусгагдаагүй зүйлсийг шаардах, бүрдүүлэх эрх хэмжээ нь одоогоор хууль бусад хэм хэмжээнд тусгагдаагүй. Иймд ШЕЗХ-ны ажлын албаны эрх хэмжээг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд илүүтэйгээр тодорхой болгох шаардлагатай нь харагдаж байна. Учир нь ШЕЗХ-оос шийдвэрлэсэн ёс зүйн маргаан цаашид Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх (ЗХДЗШШ)-ээр хянагдаж буй нь шүүх давж заалдах журмаар маргааныг хянан шийдвэрлэж байгаа гэх утгаараа хууль дээдлэх зарчмын үндсэн дээр хэрэгжсэн эсэхийг хянах шаардлага үүсэж байгаа юм.

4. Ёс зүйн хорооны гишүүний хараат бус байдал ба түүний баталгаа

ШЕЗХ-ны маргаан хянан шийдвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч чухал субъект нь түүний гишүүн билээ. ШЕЗХ-ны гишүүн тус чиг үүргийг өөрийн үндсэн ажлын хажуугаар зэрэгцүүлэн гүйцэтгэж байгаа нь маргааныг нэг бүрчлэн

шударгаар шийдвэрлэхэд багагүй хүндрэл учруулж болохоор байна. Мөн ШЕЗХ-ны гишүүн нэг сарын 200,000 төгрөгийн урамшуулал авч буй нь гүйцэтгэж буй чиг үүргийн ач холбогдолтой нь харьцуулахад бага гэж үзэхээр байна.

ШЕЗХ-ны гишүүн маргаан хянан шийдвэрлэх үндсэн чиг үүргээсээ гадуур шүүхийн процесст биечлэн оролцох нь хараат бус байдлын хувьд зохимжгүй юм. “ШЕЗХ-ны гишүүн” гэх албан тушаал орон тооны бус бөгөөд өөр ажилтай хавсран гүйцэтгэж болдог. Ёс зүйн хорооны гишүүний үүргийг гүйцэтгэх хугацаандаа шүүгч, өмгөөлөгч, прокурор зэрэг албан тушаалыг давхар эрхлэх нь ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ.

Ёс зүйн гомдол гаргагчид гомдлоос татгалзах

ШЕЗХ-д гомдол гаргагчдын хувьд өөрийн гаргасан гомдлоос татгалзах тохиолдол түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэн, хуулийн этгээд гаргасан гомдлоо эгүүлэн татах буюу татгалзах эсэх асуудлыг эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бусад эрх зүйн хэм хэмжээгээр нарийвчлан зохицуулаагүй. Дээрх байдал нь шүүгчийн хараат бус байдалд шууд бусаар нөлөөлөх боломжийг үүсгэж болох талтай. Тухайлбал, анхан шатны шүүхийн шүүгчдийн хувьд хянан шийдвэрлэх маргааны тоо их байдаг. Гэтэл үүнтэй зэрэгцэн ёс зүйн гомдолтой холбоотойгоор түүнд хариу тайлбар гаргах зэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас үл хамаарсан ачаалал ихээр үүсдэг байна.

ШЕЗХ-ны шийдвэрт давж заалдах ба шүүгчийн хараат бус байдал тусгах нь

Монгол Улсын өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй тогтолцоонд энэхүү харилцааг хэм хэмжээний онцлогоос хамааран хэт ерөнхий зохицуулснаас үүдэн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа болон маргаанд оролцогчдын эрх хэмжээ тодорхойгүй болсон. Олон улсын туршлагаас харахад шүүгчийн ёс зүйтэй холбогдох сахилгын хэргийн

хувьд давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэх эрх хэмжээг харьцангуй шат дамжлага багатай байхаар зохицуулж байна. Тухайлбал, Шүүгчийн сахилгыг хянан шийдвэрлэх загвар бүхий улс орнуудын хувьд давж заалдах гомдлыг аль нэг институцээс хянах хэлбэрээр хязгаарладаг. Жишээ нь, Польш Улсын хувьд сахилгын хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах тохиолдолд гагцхүү дээд шүүхийн дэргэдэх сахилгын шүүхэд гаргаж болохоор заасан бөгөөд шүүх шийдвэрээ 2 сарын дотор гаргах бөгөөд шүүхийн шийдвэр эцсийн байна. Энэ байдал шүүгч хэмээх онцгой эрх бүхий субъектийн хараат бус байдлыг хамгаалах шаардлагаас үүдэлтэй юм.

5. Шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо

Өнөөдөр манай улсад хэрэгжиж буй тогтолцооны дагуу сахилгын хэргийг мөрдөн шалгах, хянах, нотлох ба хянан шийдвэрлэх чиг үүрэг нь хоёр бие даасан институцэд (ШЕЗХ, Шүүх) хуваарилагдсан шинжтэй байгаа нь дэлхий нийтэд хэрэгжиж буй бусад тогтолцооноос ялгаатай байна. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд (1) ШЕЗХ нь мөрдөн шалгах, хянах, нотлох болон хянан шийдвэрлэж шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах хэлбэрээр хэрэгжиж байна. (2) Шүүхийн хувьд хууль болон дүрэмд заасны дагуу ШЕЗХ-ны бүх гишүүдийн хурлын шийдвэрт давж заалдах гомдол гаргаснаар шүүхийн ажиллагаа хэрэгжинэ. Энэ хүрээнд ЗХДЗШШ болон УДШ-ийн ЗХТ-ийн хувьд хяналт тавих болон сахилгын хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг гүйцэтгэж байна. Гэвч дээрх шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсэж буй дараах хүндрэлтэй асуудлыг авч үзье.

Шүүхийн өмнөх шат буюу ШЕЗХ-ноос гомдол хянан шийдвэрлэх хүрээнд

Монгол Улсын хувьд шүүхийн өмнөх процесс буюу ШЕЗХ-ны шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдлыг хянан хэлэлцэх (3 гишүүн) болон сахилгын хэргийг хянан шийдвэрлэх хүрээнд уг тогтолцоо нь чиг

үүргийн давхардсан шинжийг агуулж байна. Өөрөөр хэлбэл, хянан шийдвэрлэх эрх хэмжээ болон түүнээс гаргах эрх зүйн үр дагавар нь ялгаатай боловч шүүгчийн хараат бус байдлын үүднээс харвал гомдлыг бүх гишүүдийн хурал л эцэслэн шийдвэрлэдэг. Гомдлыг хянан шийдвэрлэсэн сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзсан тогтоол нэг бүрийг нийт гишүүдийн хурал хянан шийдвэрлэж буй нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалал, цаг хугацааны хувьд бэрхшээл учруулж болох юм.

Түүнчлэн тогтолцооны хувьд шүүхийн өмнөх буюу ШЁЗХ-ны хувьд сахилгын хэргийг нотлох, хянах шийдвэрлэх хүрээнд шүүхийн шаттай агуулгын хувьд давхардсан шинжтэй байна.

Хянан шийдвэрлэх чиг үүргийн хүрээнд

ШЁЗХ-ны маргаан шийдвэрлэх хүрээнд гаргаж буй бүх магадлал нь цаашид ЗХДЗШШ-д хянан шийдвэрлэгдэх боломжтой. Иймд шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар нарийвчилсан процессын журам байхгүйгээс үүдэн чиг үүргийн хувьд уг тогтолцоо (1) шүүгчийн ёс зүйн хүрээнд үүсэх асуудлыг хянах, эсвэл (2) ШЁЗХ-ны үйл ажиллагааг хянах чиг үүргүүдийн алийг нь хэрэгжүүлж буй нь тодорхойгүй болж байна.

Монгол Улсын шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдлыг шалгах, нотлох, хянах, шийдвэрлэх чиг үүрэг бүхэлдээ ШЁЗХ-нд хамаарч шүүхийн журмаар хянах чиг үүрэг нь давж заалдах, хяналтын шатны шүүхийн хүрээнд хамаарч байна. Гэвч уг тогтолцооны хувьд шүүхийн үе шатыг давж заалдах гомдлыг хянах агуулгаар авч үзэх юм бол манай улсын тогтолцоо нь ШЁЗХ-нд дээрх чиг үүргүүд болох гомдлыг хянах, нотлох, шийдвэрлэх чиг үүрэг төвлөрсөн тогтолцоо хэмээн үзэж болох мэт боловч дээрхийг няцаах гол үндэслэл нь дээр дурдсан шүүхүүд ШЁЗХ-ны шүүгчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг хүчингүй болгож буй агуулгаараа угтаа сахилгын маргааныг хянан шийдвэрлэж байна гэж үзэж болохоор юм. Иймд манай улсын хувьд шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо нь чухам шүүгчийн сахилгын хэргийг

хянан шийдвэрлэх аль загварт хамаарах эсэх нь нэн чухал шийдвэрлэх асуудал болжээ.

Улс орон бүрийн шүүхийн сахилгын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа харилцан адилгүй бөгөөд нийтлэг утгаараа ёс зүйн зөрчилтэй холбоотойгоор сахилгын шийтгэл оногдуулах процесс богино хугацаанд явагдаж байна. Гэтэл дээрх тогтолцооны онцлогоос хамааран шүүгчийн сахилгыг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий хугацаа уртсах буюу захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацаатай адил үргэлжлэх боломжтой байгаа юм.

6. Шүүгчийн хариуцлага түүнтэй холбогдох эрх зүйн орчны хүрээнд

Шүүхийн ёс зүйн хорооны эрх зүйн статус ба эрх зүйн орчин

ШЁЗХД-ийн 2.1-т “Ёс зүйн хороо нь шүүгчийн сахилга, хариуцлага, ёс зүйг сахин хамгаалдаг орон тооны бус байгууллага мөн. Ёс зүйн хороо үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга, ил тод, төвч голч байх, гомдлыг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно” хэмээн заасан. Үүнээс үүдэн ШЁЗХ-ны эрх зүйн статус хэрхэх вэ? гэх асуулт ургаж гарна. Өөрөөр хэлбэл, түүний эрх зүйн статусаас үүдэн уг байгууллага “орон тооны бус” гэх статус нь чухам түүний бүрэн эрх, эрх хэмжээнд хэрхэн нөлөөлөх бэ? гэх эргэлзээг төрүүлж байна. Тэгвэл Захиргааны ерөнхий хуулийн 5.1.5-т “... шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага” гэх зохицуулалт байна. Үүнээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль ёсоор ШЁЗХ-ны бүх гишүүдийн хуралдааны магадлалыг эс зөвшөөрвөл түүнийг ЗХДЗШШ-ээс хяналтын журмаар хянан шийдвэрлэх боломжтой билээ. Энэ шинж нь ШЁЗХ-г захиргааны байгууллага болохыг нотолж байна. Дээрхээс үүдэн ШЁЗХ нь өөрийн үйл ажиллагааг захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх эсэх асуудал эргэлзээ төрүүлнэ. Энэ байдал нь ШЁЗХ-ны хувьд ЗХДЗШШ-тэй хэрхэн харилцах буюу сахилгын

хэргийн хувьд шүүхийн үе шатанд нь давж заалдах уу? эсвэл хянан шийдвэрлэх үү? хэмээх асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой болох юм.

Дээрхээс гадна ШЕЗХ-ны эрх зүйн статусыг тодруулах нь цаашид ШЕЗХ-ны үйл ажиллагаа захиргааны байгууллага болох эсэхээс хамааран түүний үйл ажиллагааг бие даан хянах, эсвэл шүүгчийн ёс зүйн зөрчилд холбогдох тусгай байгууллага болох агуулгаараа гагцхүү түүнийг шийдвэрийг давж заалдах журмаар хянуулах хүрээнд онцгой ач холбогдолтой юм.

Эрх зүйн хэм хэмжээ болон чиг үүргийн давхардал

Монгол Улсын хувьд шүүхийн шинэтгэлийн хүрээнд батлагдан гарсан шүүхийн багц хуулиудтай зэрэгцэн шинэчлэл хийсэн тогтолцоо бол хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хуульчдын мэргэжлийн үйл ажиллагааны шинэчлэл болсон өөрийн удирдлагын байгууллагатай болсон явдал байсан. Энэ хүрээнд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах хэм хэмжээг батлан гаргасан. Үүнээс үүдэн зарим талаараа шүүгч хэмээх албан тушаалын хувьд ёс зүйн дүрмийг баримтлах мөн хуульч гэх байдлаараа хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлах шаардлагатай болсон юм. Үүнээс үүдэн нэг фактаас үүдэлтэй хоёр өөр процесс зэрэгцэн орших боломжийг бий болгожээ. Энэ нь Шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан тухай нэг асуудлын талаар ШЕЗХ эсхүл Мэргэжлийн хариуцлагын хорооны алинд нь ч хандах боломжтой. Шүүгчийн ёс зүйн асуудлаар энэ хоёр хорооны аль ашигтайд нь хандах, нэг асуудлаар хоёр өөр шийдвэр гарах боломжтой байгаа нь процессын шударга ёс алдагдах эрсдэл дагуулж байна.

7. ШЕЗХ болон шүүхийн ил тод байдал

Судалгааны ажлын хүрээнд шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикийг судлах явцад ажиглагдсан нэг зүйл нь энэхүү маргааны талаарх мэдээлэл хязгаарлагдмал хаалттай байдаг. Энэ нь шүүхийн ил тод

байдалтай шууд холбогдох бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, дүрмийн хүрээнд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа болон түүний шийдвэрийг иргэд, судлаачид нээлттэй байдлаар судлан үзэх боломж хязгаарлагдмал байна. Хэдийгээр хуульд дээрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй боловч практикт шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ШЕЗХ-ны шийдвэрүүдийн зарим хэсэг, ЗХДЗШШ-ийн магадлалын хувьд бүхэлдээ шүүхийн нээлттэй мэдээллийн сан болох цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь шүүгчийн сахилгын хэргийн хувьд хуульд хэдийгээр хориглосон зүйл байхгүй боловч түүнийг хэрэгжүүлэх практик шүүгчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрүүд иргэдэд нээлттэй бус буюу мэдээлэл олж авах асуудал хязгаарлагдмал шинжтэй байгааг харуулж байна.

8. ШЕЗХ-ны гишүүд ба ШЕЗ-ийн мэргэжилтний хүртээмжтэй байдал

Иргэд, хуулийн этгээдийн зүгээс ШЕЗХ-нд шүүгчийн ёс зүйн асуудлаар хандах нь улам бүр нэмэгдэх хандлагатай байна. 2015-2016 оны дунджаар жилд 300 орчин гомдол ирж байсан нь цаашид энэ ачаалал нэмэгдэх хандлагатай болохыг илтгэнэ. Одоо эрх зүйн зохицуулалтаар ШЕЗХ-ны ажлын алба гомдол шалгах, гишүүдэд туслах чиг үүргийг гүйцэтгэхээр заасан. Тэгвэл ШЕЗХ-ны ажлын алба нь эдүгээ Ажлын албаны дарга, референт 3, шинжээч 1 гэсэн орон тоотой энэхүү чиг үүргээ хэрэгжүүлж байна. Тэгвэл шүүгчийн ёс зүйтэй холбогдох шалгалтын хүрээнд дээрх орон тоо нь цаашид урьдчилсан ямар нэг процессын журамгүйгээр ШЕЗХ-нд хандан гаргасан бүхий л гомдлын хүрээнд урьдчилсан шалгалтыг хийх хүрээнд цаашид уг албаны ажилтны орон тоог нэмэгдүүлэх шаардлага үүсэж болзошгүй юм.

Ингэснээр ШЕЗХ нь нэгэнт орон тооны бус байх учир ШЕЗХ-ны өдөр тутмын ажил уг албаар дамжин хэрэгжих хүрээнд ач холбогдолтой төдийгүй шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулахад чухал үр нөлөөтэй.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад өрнөж буй шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд цөөнгүй ажил богино хугацаанд хийж, хэрэгжүүлээд байна. Энэхүү шинэтгэлээр бий болсон соёл, хандлага бүрэлдэн бэхжиж буй эрх зүйн шинэ орчин хэдийнээ амьдралын тодорхой тохиолдол шүүхийн практик бий болжээ. Үүний нэг нь шүүгчийн хариуцлагын тогтолцооны нэг хэсэг болох шүүгчийн ёс зүй, сахилгын асуудлыг шийдвэрлэх тогтолцоо юм.

Энэхүү судалгааны хүрээнд өнөөгийн Монгол Улс дахь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Зөвлөмжийг дөрвөн үндсэн чиглэлийн хүрээнд авч үзсэн болно.

1. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Шүүгчийн хариуцлагын тогтолцооны үндсэн хэсэг нь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүний тогтолцоо юм. Манай улсын шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрийн суурь уламжлалтай хэдий ч шүүхийн шинэтгэлийн бодлогын үр дүнд уг тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд бий болсон. Хэдийгээр уг өөрчлөлтийн хүрээнд шүүгчийн хариуцлагын институт боловсронгуй болж буй хэдий ч зарим чухал асуудал шийдэл хүлээсэн хэвээр байна. Иймд өнөөгийн тогтолцоог хэвээр хадгалах тохиолдолд дараах эрх зүйн өөрчлөлтийг оруулахыг зөвлөж байна:

- *Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээний ерөнхий зохицуулалтыг тодорхой болгох.* Тухайлбал, шүүхийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрүүгийн буюу зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдох зарчимд нийцүүлэн тусгайлан журамлах замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцлагатай, үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх
- *Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нотлох баримт цуглуулах ажиллагаанд ШЕЗХ, түүний гишүүн, ажлын албаны чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхой болгох.* Шаардлагатай тохиолдолд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс нотлох баримтыг шүүхээр уламжлуулан шаардан гаргуулж болох эрх хэмжээг олгох, гомдол гаргагч, шүүгчээс маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах.
- *Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд ШЕЗХ-ны ажлын албаны эрх хэмжээг процессын хуультай нийцүүлэн нарийвчлан зохицуулах.* Ингэснээр ШЕЗХ-ны гишүүн ёс зүйн гомдлыг шалгах ажиллагааг түргэн, шуурхай, үр нөлөөтэй явуулахад ач холбогдолтой.
- *ШЕЗХД-ээр гишүүний эрх хэмжээ, чиг үүргийг нарийвчилж зохицуулах.* ШЕЗХ-ны гишүүний хараат бус байдлыг баталгааг тогтоох хүрээнд ШЕЗХ-ны гишүүний бүрэн эрхийн хугацаанд шүүхийн маргаан хянан

шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн хэн нэгний хүсэлтээр үндсэн болон бусад оролцогчоор төлөөлж оролцохыг хязгаарлах. Тухайлбал, ШЁЗХ-ны гишүүн өөрийн бүрэн эрх хэрэгжиж байх хугацаанд шүүхэд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчөөр оролцох байдлыг хориглох.

- *ШЁЗХ-нд хандан гаргасан гомдлоос гомдол гаргагч аль ч үе шатанд татгалзаж буйг хязгаарлах.* Зарим ноцтой гомдлын хувьд гомдол гаргагчийн татгалзлаас үл хамааран маргааныг хянан шийдвэрлэж болох эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- *Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хүрээнд ШЁЗХ-нд хандан гаргасан гомдол бүрийг ижил процессоор хянан шийдвэрлэх болон ялгаатай байдлаар авч үзэх эсэх асуудлыг судалж үзэх.*
- *Шүүгчийн сахилгын зөрчилд хариуцлага хүлээлгэх хэт богино хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг судалж, уртасгах, зарим ноцтой тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх боломжийг бий болгох.*
- *ШЁЗХ-ны шийдвэрт давж заалдах эрхийн хэрэгжилтийн хүрээнд хязгаартайгаар хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.* Учир нь ШЁЗХ нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргааныг анхлан хянан шийдвэрлэх онцгой бүрэн эрхтэй боловч ЗХДЗШШ болон УДШ-ийн ЗХТ нь тус маргааны хүрээнд дан ганц ШЁЗХ-ны шийдвэрийг хянах хүрээнд бус маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээг эдэлж байна. Иймд дээрх тохиолдолд шүүгчийн сахилгын маргааныг хянан шийдвэрлэх хугацаа, агуулгын хүрээнд хязгаарлалт тогтоох замаар шүүгчийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай.

2. Шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо

Эдүгээ дэлхий дахинд шүүгчид хариуцлага хүлээлгэх хүрээнд шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх үндсэн гурван загвар нэгэнт тогтжээ. Харин манай улсын шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх тогтолцоо, түүний суурь чухам аль хандлага, загварт чиглэж буй нь тодорхойгүй байх шинж ажиглагдаж байна. Иймд уг асуудлыг боловсронгуй болгох, шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх өнөөгийн тогтолцоог өөрчлөх хүрээнд дараах саналуудыг зөвлөж байна. Үүнд:

- *Монгол Улсад эдүгээ хэрэгжиж буй шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх загварыг тодорхой болгох.* Өнөөгийн шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо нь дэлхий нийтийн шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх аль нэг загварт шууд хамаарахгүй буйгаас үүдэн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн өмнөх болон шүүхийн шатыг дамжин хэрэгжиж байна. Иймд цаашид шүүгчийн сахилгыг хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог аль нэг загварт ойртуулах замаар сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийн давхардлыг арилгах нь зүйтэй. Улмаар дээрх сахилгын хэрэг хянан шийдвэрлэх загварын хүрээнд сахилгын хэргийг мөрдөн шалгах, нотлох, хяналт тавих болон хянан шийдвэрлэх чиг үүргийг сонгож буй

тогтолцооны хүрээнд хуваарилах.

- *ШЕЗХ-ны магадлалыг буюу шийдвэрийг шүүхээс хянах (ЗХДЗШШ болон УДШ-ийн ЗХТ) эсвэл шүүгчийн сахилгын маргааныг хянан шийдвэрлэх эсэх асуудлыг зааглаж үзэх.* Өөрөөр хэлбэл, шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх процесст шүүхийн оролцоог бусад төрлийн хэргээс харьяалал, хугацаа, шүүхийн эрх хэмжээний хувьд ялгамжтай авч үздэг эрх зүйн орчныг буй болгох.
- *Шүүгчийн хараат бус байдлыг хангах хүрээнд ШЕЗХ-нд иргэд, байгууллагаас хандан гаргаж буй гомдлын агуулга илтэд ёс зүйн хорооны харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй асуудлын хүрээнд урьдчилсан шалгалтыг хийх байдлаар шүүгчээс тайлбар гаргуулж авах харилцааг хялбарчилсан байдлаар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.*
- *ШЕЗХ-ны сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хүрээнд давхардсан шинжтэй хоёр үе шат бүхий процессыг халах.* ШЕЗХ-ны хуралдаанаас сахилгын хэрэг үүсгэх, эсэх талаарх тогтоол гаргах боловч уг тогтоол нь ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэхгүй юм. Үүнээс үүдэн тогтолцооны хувьд сахилгын хэргийг шалгах, нотлох чиг үүргийг хэрэгжүүлсэн гишүүн нь нийт гишүүдийн хурлын хувьд нотлох (яллах), хянан шийдвэрлэх чиг үүргийг гүйцэтгэж буй тул дээрх процессыг нэгтгэх замаар өөрчлөх, эсэхийг судлах.

3. Шүүгчийн хариуцлага ба түүнд холбогдох эрх зүйн орчин

Шүүгчийн хариуцлагын хүрээнд өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдуулан дараах саналыг зөвлөж байна. Үүнд:

- *ШЕЗХ-ны эрх зүйн статусыг тодорхой болгох.* Өнөөгийн ШЕЗХ-ны дүрэм болон бусад эрх зүйн хэм хэмжээнд зааснаар тус хорооны эрх зүйн статус байнгын бус, үйл ажиллагаа нь захиргааны байгууллагын шинжийг агуулах шинжтэй байна. Иймд шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог өөрчлөх боломжгүй гэж үзвэл түүний эрх зүйн статусыг нарийвчлан заах байдлаар шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх хүрээнд ямар эрх хэмжээтэй оролцохыг тодорхой болгох шаардлагатай.
- *Хуульчийн ёс зүйн болон шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох эрх эрх зүйн зохицуулалт чиг үүргийн давхардлыг арилгах.* Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтаар хуульчийн холбооны мэргэжлийн хариуцлагын хороо болон ШЕЗХ-ны шүүгчийн ёс зүйн хариуцлага, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа чиг үүргийн хувьд давхардсан шинжтэй боловч, тогтолцооны хувьд уялдсан шинжийг агуулахгүй байна. Иймд цаашид шүүгчийн хариуцлагаас гадна түүний суурь болсон хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцоог өөр хооронд нь уялдуулах шаардлагатай юм.

- *Шүүгчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргасан этгээд цаашид хуульчаар ажиллаж болох эсэхийг тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх.* ШЕЗХ болон Хуульчийн мэргэжлийн хорооны үйл ажиллагааны хүрээний чиг үүргийн давхардал нь шүүгчийн ёс зүйн хувьд ноцтой зөрчил гаргаж хариуцлага хүлээсэн этгээд цаашид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх хэмжээг эдлэхгүй байх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй. Ингэснээр нэг зөрчилд шийтгэлийг давхардуулан олгохгүй байх улмаар ёс зүйн зөрчил гаргасан этгээдийн хувьд эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдлаас үүдэн хариуцлагаас гадуур байх боломжийг хязгаарлана.

4. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох бусад үйл ажиллагаа

Судалгааны багийн зүгээс өнөөгийн байдлаар шүүгчийн хариуцлагын тогтолцооны хүрээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дараах саналыг зөвлөж байна. Үүнд:

- *Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд бий болж буй шийдвэрүүдийг судлаачид, иргэд үзэж болох байдлаар нээлттэй болгох.* Эдүгээ уг асуудал харьцангуй нээлттэй боловч сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрүүдийн хувьд хаалттай байгаа нь судалгаагаар тогтоогдож буй. Иймд ШЕЗ болон шүүхийн нээлттэй цахим хуудсаар дамжуулан бүх шийдвэрийг нээлттэй болгох нь ШЕЗХ болон шүүхэд итгэх иргэд, судлаачдын итгэлийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн шүүгчийн ёс зүйд тавих иргэдийн хяналт дээшлэх боломжтой.
- *ШЕЗХ үйл ажиллагааны гол цөм болсон ШЕЗХ-ны ажлын албаны орон тоог нэмэгдүүлэх.* Тус ажлын алба нь сахилгын маргаан хянан шийдвэрлэх хүрээнд шүүгчид, гомдол гаргагч, ШЕЗХ-ны гишүүний хувьд холбох гүүр болж байна. Гэтэл тус ажлын албаны орон тоо, хараат бус байдлыг баталгаажуулсан эрх зүйн орчин хомс бөгөөд энэхүү асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай.
- Хэргийн оролцогчдод чиглэсэн Шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүгчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлага, шүүгчийн ёс зүйн асуудлаар гомдол гаргах үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулснаар үндэслэлгүй гомдлын тоо, ШЕЗХ-ны ачааллыг багасгах, иргэд олон нийтийн Тус зарчмын 13 дахь хэсэгт шүүхийн бие даасан болон шүүгчийн ёс зүйтэй байдлыг шүүхийн тогтолцооны үр ашигтай, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл хэмээн тайлбарласан. Өөрөөр хэлбэл, шүүгчийн хариуцлагын асуудал нь энэ тогтолцооны амин чухал хэсэг болохыг тод томруунаар харуулж байгаа юм. хяналтыг сайжруулах ач холбогдолтой юм.